



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2018 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 06

Мандалговь

Хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 4, 5.8 "б" дэхь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Говь-Угтаал сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 22,360,400.00 /Хорин хоёр сая гурван зуун жаран мянга дөрвөн зуун төгрөг/-ний анхны өртөгтэй, 8,571,486.6 /Найман сая таван зуун далан нэгэн мянга дөрвөн зуун наян зургаан төгрөг жаран мөнгөн/-ний хуримтлагдсан элэгдэл бүхий 25-26 ДУА улсын дугаартай УАЗ-220695 маркын автомашиныг Говь-Угтаал сумын Есөн жилийн дунд сургуульд, тус сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 58,070,000 /Тавин найман сая далан мянган төгрөг/-ний анхны өртөгтэй 2,613,055.6 /Хоёр сая зургаан зуун арван гурван мянга тавин таван төгрөг жаран мөнгө/-ний хуримтлагдсан элэгдэл бүхий цаг уурын өртөөний барилгыг аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг зохих хууль журмын дагуу байгууллагын данс бүртгэлээс хасахыг Говь-Угтаал сумын Засаг даргын тамгын газар /Г.Эрдэнэцэцэг/-т, бүртгэж авахыг Говь-Угтаал сумын Есөн жилийн дунд сургууль /Б.Оюунтөгс/, Дундговь аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газар /Я.Мажаасүрэн/-т нарт тус тус даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоожид үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

0100010